

## Гарчиг

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА -----	3
1.1. Баяжуулах технологи -----	4
1.2. Баяжуулах үйлдвэрийн ажлын горим -----	6
1.3. Бүтээгдэхүүн гаргалт -----	6
1.4. Инженерийн хангамж -----	6
1.5. Үйлдвэрийн барилга байгууламж -----	8
1.6. Хаягдлын байгууламж -----	10
2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ -----	12
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ -----	13
4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ -----	15
4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ -----	16
4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ -----	18
4.3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ -----	19
4.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ -----	20
4.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ -----	21
4.6. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ -----	22
4.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ -----	24
4.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ -----	26
4.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ -----	28
4.10. 2023 ОНЫ БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ МЭДЭЭ -----	29

### Хүснэгтийн жагсаалт


Хүснэгт №1. Хүдэр баяжуулах үйлдвэрийн ажиллах горим .....	6
Хүснэгт №2. Баяжуулалтын бүтээгдэхүүний баланс .....	6
Хүснэгт №3. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр .....	13
Хүснэгт №4. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа .....	14
Хүснэгт №5. 2023 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв .....	16
Хүснэгт №6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	18
Хүснэгт №7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
Хүснэгт №8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	20
Хүснэгт №9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв .....	21

Хүснэгт № 10. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төсөв.....	22
Хүснэгт № 11. Хог хаягдлын менежментийн төсөв .....	24
Хүснэгт № 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв .....	26
Хүснэгт № 13. Удирдлага зохион байгуулалтын төсөв .....	28
Хүснэгт № 14. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах мэдээ.....	29
Хүснэгт № 15. Байгаль орчны менежментийн төсөв .....	30

### **НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Тус Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь 2015 онд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших 10 га талбайд үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Монгол орны ихэнх ордуудын үйлдвэрлэлийн ач холбогдолтой жоншны хүдэр нь кварц-флюоритийн төрөлд хамрагддаг, ашигтай эрдэс нь  $\text{CaF}_2$  байгаа ба флюоритийн багагүй агуулгатай, өнгөгүй, цөөн тохиолдолд ногоон ягаан өнгөтэй карбонатын маш бага агуулгатай, хорт хольц болох сульфид, фосфор бага байдаг учир өндөр чанарын баяжмал гарган авах боломжтой нь олон ордын хүдрийн шинж чанарын шинжилгээний дүнгээс харагдаж байна.

2023 онд  $\text{CaF}_2$  43.0 % агуулгатай 10 мян.тн хүдрийг боловсруулж, 97%  $\text{CaF}_2$ -ийн агуулга, 35.9% гарц, 81.0% эрдэс авалттай 3.6мян.тн жоншны баяжмал гарган авна. Хүдрийн нөөцийг Сити сүлжээ ХХК-ийн Дэлгэр 3-ын жоншны уурхайгаас 10 мян.тн хүдэр худалдан авах гэрээ байгуулсан.




Зураг №1. Жонш баяжуулах үйлдвэрийн байршил

### 1.1. Баяжуулах технологи

Баяжуулах үйлдвэр нь бутлах цех, төв корпус, шүүн хатаах цех, хаягдлын аж ахуй гэсэн цех хэсгүүдтэй байх бөгөөд энэ нь хоёр шатны бутлалт, нунтаглалт хийсний дараа хүдрээс флюоритын эрдсийг ялгах үндсэн ба хяналтын, цэвэрлэгээний флотацийн шат дамжлагуудаас бүрдэнэ. Үүнд:

- хүдэр хүлээн авах талбай
- хүдэр бутлах цех
- нунтаглан баяжуулах хэсэг
- баяжмал өтгөрүүлэх, шүүх хэсэг.
- баяжмалыг хатаах, савлах, хадгалах хэсэг
- хаягдлын болоод цэвэр усны цөөрөм, худаг зэрэг болно.



Зураг №2. Баяжуулах үйлдвэрийн технологийн схем

## 1.2. Баяжуулах үйлдвэрийн ажлын горим

Баяжуулах үйлдвэр нь жилд 240 хоног, 3 ээлж, 7 цагаар ажиллахаар төлөвлөгдсөн.

Хүснэгт №1. Хүдэр баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

№	Үзүүлэлтүүд	Тоон утга
1	Өдөрт ажиллах бодит цаг	21
2	Сард ажиллах бодит цаг	641
3	Жилд ажиллах бодит цаг	5040
4	Жилд ажиллах хоног	240
5	Цагийн хүчинчадал, тн/цаг	1.98
6	Хоногийн хүчин чадал, тн/хоног	41.58
7	Сарын хүчин чадал, тн/сар	1247.4
8	Жилийн хүчин чадал, тн/ жил	10,000

Баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадлыг дараах томъёогоор тодорхойлов.

$$Q1=Qж : T1= 10000 : 5040 = 1.98 \text{ тн/цаг}$$

Үүнд: Q1–баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал, тн/цаг

T1 – баяжуулах үйлдвэрийн жилд ажиллах хугацаа, цаг

Уурхайгаас нийлүүлж буй жоншны хүдрийг үйлдвэрийн дэргэдэх хүдэр дундажлах талбайд автотээврээр зөөвөрлөн авчирна. Буталсан хүдэр бункерээс туузан дамжуулагчаар бөөрөнцөгт тээрэмдорж 65-85% нь 200 меш болтол нунтаглагдсаны дараа хөвүүлэн баяжуулалтанд орно.

## 1.3. Бүтээгдэхүүн гаргалт

Технологийн схемийн тоо чанарын үзүүлэлтийн тооцоо нь технологийн процессын үйлдэл ба бүтээгдэхүүн тус бүрийн чанарын үзүүлэлтүүд болон тоон үзүүлэлтүүдийг тодорхойлодог. Бүтээгдэхүүний тоон үзүүлэлтэнд бүтээгдэхүүний гарц, хүдрийн хэмжээг тодорхойлох ба чанарын үзүүлэлтэнд бүтээгдэхүүн дэх металлын агуулгыг тодорхойлно. Баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал 10.0 мян.тн 43.0 % CaF<sub>2</sub> дундаж агуулгатай хүдэр баяжуулж ФФ97%-ийн флюоритийн агуулгатай баяжмал гаргах юм.

Хүснэгт №2. Баяжуулалтын бүтээгдэхүүний баланс

№	Бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүн, тн/жил	Агуулга, %	Гарц, %	Эрдэс авалт, %
1	Баяжмал	3591	97.0	35.91	81.0
2	Хаягдал	6409	12.75	-	19.0
3	Анхдагч хүдэр	10.000	43.0	-	-

## 1.4. Инженерийн хангамж

**Усан хангамж:** Баяжуулах үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, баяжуулах төхөөрөмжүүдийг хэвийн ажиллуулахад шаардлагатай усны зарцуулалтыг тооцов. Хүдэр баяжуулалтын технологийн усан хангамж нь эргэлтийн ба гүний цэвэр усны худгаар хангагдана. Баяжуулах үйлдвэрийн ус хангамжийг 3 хуваан үзэж болно.

- Ахуйн хэрэглээний усан хангамж

- Технологийн цэвэр усан хангамж
- Эргэлтийн усан хангамж

Хэрэглээний буюу ундны усыг худгийн усаар хангана. Зарцуулалтын норм нь 3 м<sup>3</sup>/хоног, Технологийн усыг мөн худгийн усаар хангаж 2х1000 м<sup>3</sup> багтаамжтай ёмкостоор дамжин хэрэглэнэ.

Баяжуулах технологид хэрэглэгдсэн нийт ус нь хаягдлын аж ахуйд хаягдаж, цэвэрлэгдээд 90% нь эргүүлэн үйлдвэрлэлд эргэлтийн ус болон зарцуулагдана. Баяжуулах үйлдвэрт зарцуулагдах нийт усны зөвхөн 10% цэвэр усаар сэлбэгдэнэ. Хаягдлын шүүгдсэн цэвэршсэн ус нь эргэлтийн усны цөөрөмд хуримтлагдах ба технологид эргүүлэн насосоор шахагдаж өгөгдөнө. Эргэлтийн усыг хүдэр нунтаглах, баяжуулах, цэвэрлэгээний процесст хэрэглэдэг. Эргэлтийн уснаас гадна технологийн процесст цэвэр усыг нэмж хэрэглэдэг.

Баяжуулах цехийн жилд хэрэглэгдэх ус ны хэрэгцээг тооцвол:

$$5.13 \text{ м}^3 \times 240 = 25855.2 \text{ м}^3/\text{жил}$$

1 тн хүдэр баяжуулахад зарцуулагдах усны хэмжээ 2.6 м<sup>3</sup> болж байна.

$$25855.2 \text{ м}^3 : 10000 = 2.6 \text{ м}^3/\text{тн}$$

Үүний 90 % буюу 23269.68 м<sup>3</sup> нь эргэлтийн усаар, нийт усны 10 % буюу 2585.52 м<sup>3</sup> нь цэвэр усаар тус тус хангагдах болно.

**Цахилгаан хангамж:** Жоншны баяжуулах үйлдвэр нь GM1557 маркийн бөмбөлөгт тээрэм, PE250x400 маркийн хацарт бутлуур, PE100x600 маркийн хацарт бутлуур, GBQ50\*965 чичиргээт шигшүүр, FG-5 маркийн мушгиа ангилуур, XJ-28 флотомашин, XJ-11 флотомашин, GW-2 маркийн вакуум филтэр, NZS-3 маркийн өтгөрүүлэгч, насос зумпф, BK-1000-20 i конвейер, BK-650-30 i конвейер, BK-500-10 i конвейер, XB-1500 контактын чан, тэжээгүүр, хатаах барабан зуух, насос /хаягдлын а/а/, кран /бутлах цех/, кран /флотацийн цех/ зэрэг цахилгаан хэрэглэгчидтэй байх бөгөөд тэдгээр хэрэглэгчид нь 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүч хэрэглэгч юм.

Тус үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт байрлалтай 35/10 кВ-ын Даланжаргалан дэд станцаас зүүн хойшоо 3 км зайд орших бөгөөд баяжуулах үйлдвэрийн тооцооны бүрэн цахилгаан ачаалал 746.41 кВА байгаа тул энэхүү чадлыг үндэслэн 800 кВА чадалтай S9-800 төрлийн 35/0.4 кВ-ын хүчний нэг трансформатортай трансформаторын дэд станцыг үйлдвэрийн дэргэд барьж байгуулсан. 35/10 кВ-ын Даланжаргалан дэд станцын шинэ өргөтгөлөөс AC-50 маркийн утастай төмөр бетонон тулгууртай өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам барив. Үйлдвэрийн 35/0.4 кВ-ын дэд станцын 35 кВ талд нь 35 кВ-ын хуурай салгуур, цэнэг шавхагч тавьж, 0.4 кВ талд нь ерөнхий автомат, гаргалгааны тоогоор автоматтай 0.4 кВ-ын иж бүрэн хуваарилах байгууламжтай. 35/10 кВ-ын Даланжаргалан дэд станцын өргөтгөл, үйлдвэрийн 35/0.4 кВ-ын дэд станцуудад Монгол Улсын Стандарчилал хэмжил зүйн үндэсний төвөөс ашиглахыг зөвшөөрч, баталгаажуулсан өндөр нарийвчлал бүхий 3-н фазын /100 В-ын/ олон үйлдэлтэй электрон, 0.4 кВ импульсийн тоолууртай.



*Зураг №3. Үйлдвэрийг ЦЭХ-ээр хангах 35/0.4 кВ-ын дэд станц*

### **1.5. Үйлдвэрийн барилга байгууламж**

Жонш баяжуулах үйлдвэр нь хүдэр нөөцлөх талбайтай автозамаар холбогдоно. Баяжуулах үйлдвэрийн баруун ба баруун хойд талд хүдрийн агуулах талбай, зүүн дээд талд хаягдлын далан байрлана. Үйлдвэрийн барилга нь галерейгаар холбогдсон бутлах цехийн 2 корпус, төв корпус, шүүн-хатаах цех, баяжмал савлах, хадгалах хэсгүүд, үйлдвэрийн дэргэдэх дотоодын дээж шинжлэх лаборатори, ажилчдын 2 сууц ,угаалгын өрөө, конторын барилгуудаас бүрдэнэ.





*Зураг №4. Баяжуулах үйлдвэрийн гадна доторхи байдал*

Ажилчдыг байрлуулах үйлдвэрийн тосгон 0.2 км зайд, 1 га талбайг эзлэн байрлана. Тосгон нь оффис, 50 хүний багтаамжтай ажилчдын байр, харуулын байр зэрэг байгууламжаас бүрдэнэ. Ажилчдын байранд халуун усны газар, боловсон бие засах газар, нэгдсэн хоолны газартай



Зураг №5. Оффис



Зураг №6. Захиргаа аж ахуй

### 1.6. Хаягдлын байгууламж

Баяжуулах үйлдвэрээс гарах нийт хаягдал нь жилд 6,409 тонн бүтээгдэхүүн, 15-20%-ийн ус хоёроос бүрдэнэ. Хаягдалд хортой хольц байхгүй.

Баяжуулах үйлдвэрээс гарсан технологийн хаягдлыг далангийн өндөрлөгөөнд ашиглахаар тусгасан. Далангийн нийт урт 120 м урт, өргөн 80 м, гүн нь 6 м, нийт эзэлхүүний хэмжээ 60 мян/м<sup>3</sup> байна.

Хаягдлын сангийн байрлуулалт нь доорхи нөхцөл шаардлагыг хангасан. Үүнд:

- Хүрээлэн буй байгаль орчин, олон нийтийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх
- Ашиглалтын үед болон хаалтын дараа тогтвортой байдлаа хадгалах
- Хаягдлыг эргүүлж ашиглах боломж бүрдсэн байх
- Хаягдлаас шүүрсэн ус гүний усанд нэвчихгүй байх нөхцөлийг хангах, нэвчилтийг хянах боломжтой байх
- Хаягдал тээвэрлэх зардал хямд байх
- Хаягдал тээвэрлэхтэй холбоотой хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл хамгийн бага байх



Зураг №7. Хаягдлын сан

## **2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ**

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт байрзүйн зургийн L-49-75 хавтгайд оршино. Энэхүү талбай Улаанбаатар хотоос зүүн өмнөд зүгт, төмөр замын дагуу 290 км зайд, Дорноговь аймгаас 149 км-ийн зайд оршино.

Газарзүйн хувьд 1100-1400 м өндөрт өргөгдсөн мөлгөрдүү оройтой ухаа толгод, хяр, хэц зонхилсон, усны хагалбарын гадарга муу хөгжсөн, уулс, хяр хоорондоо тэгш маягийн өргөн хөндийгөөр тусгаарлагдсан, байнгын урсгал усгүй, хуурай тойрмуудтай, усны хатуулаг өндөр, хүн амын ундны ус ховор, хэрэгцээг гүний худаг, жижиг худгууд хангадаг. Хүн ам нь түлшний хэрэгцээндээ аргал хөрзөн, нүүрс хэрэглэдэг. Уулс толгодын хооронд нарийвтар тэгш маягийн муруй судаг, хөндий голлон цувраа аараг толгод, гүвээтэй ба тэдгээрийн хооронд нарийн хуурай сайруудаар хэрчигдсэн тал хээрийн ландшафт зонхилдог. Ургамал зүйн хувьд тал хээрийн болон говийн шимт тачир ургамал хялгана, таана, хөмүүл зонхилно. Цаг уур салхины чиглэл баруун хойноос зүүн урагш чиглэлд зонхилох ба агаарын температурын олон жилийн дундаж нь зундаа +23, өвөлдөө -25 хэм орчим байдаг.

Жонш баяжуулах үйлдвэр нь Улаанбаатар хот хүртэл 300 км орчим зайтай бөгөөд 210 км нь Чойр хот хүртэл буюу шинэхэн хатуу хучилттай засмал замаар хүрнэ. Хот хоорондын телефон утас, хөдөлгөөн татсан харилцаа нэвтэрч, шуудан холбооны үйлчилгээний системд хамрагдсан.

Жоншны баяжмалыг экспортод гаргаснаар Монгол улсын экспортын орлогыг нэмэгдүүлэх, сум орон нутгийн хөгжил, цаашлаад улсын төсөвт хувь нэмэр оруулах юм. Мөн орон нутгийн нийгэм-эдийн засгийн таатай нөлөөг үзүүлж байна.

1. Орон нутгийн 40 гаруй иргэнийг ажлын байраар хангасан.
2. Ажиллагсдын цалин 1,800,000-2,500,000 төгрөг ба энэ нь бүс нутгийн дундаж жишгээс багагүй байгаа.
3. Үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмжид шаардагдах шатах тослох материалыг сумын шатахуун түгээгүүрээс, зарим шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал, түүхий эд, хүнсний хангамжаа Даланжаргалан сумын аж ахуй эрхлэгчдээс худалдан авдаг.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт № 3. Болзошгүй нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр	Нөлөөллийн шинж чанар
<b>Агаар орчин</b>			
1	Тоосжилт	Үйлдвэрийн үйл ажиллагаа Хүдрийн овоолго Тээвэрлэлт	Улирлын чанартай Хамрах хүрээ хязгаарлагдмал Амархан сарнина
2	Хийн хаягдал, утаа	Автомашин Үйлдвэрийн автотехникүүд	Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр Хадгалагдах ба тархах хүрээ хязгаарлагдмал Амархан сарнина
<b>Усан орчин</b>			
3	Хатуу болон шингэн хог хаягдал	Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал	Шатах тослох материал асгарснаас хөрс, хөрсний ус бохирдох Хур борооны усаар аливаа хог хаягдал, асгаралт угаагдаж хөрсний ус бохирдуулах
4	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Үйлдвэрийн баяжуулалтын үйл ажиллагаа	Үйлдвэрийн явцад хөрсний ус илэрч, карьер усанд автах
<b>Хөрсөн бүрхэвч, геологийн тогтоц</b>			
5	Хөрсний элэгдэл, эвдрэл	Хөрс хуулалт Автотехникийн үйл ажиллагаа	Хамрах хүрээ хязгаарлагдмал Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөх
7	Бохирдол	Ахуйн хог хаягдал ил задгай асгах	Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана
<b>Ургамлын нөмрөг</b>			
8	Ургамлын талхагдал	Авто зам Ашиглалтын талбай, барилга байгууламжуудын орчин Тоосжилт	Хэмжээ хязгаарлагдмал ба ургамалжуулалт хийснээр нөхөн сэргэх Тухайн орчны ургамалан нөмрөгийн төрөл зүйл багасах, хомсдох
9	Ургамлын нөмрөг устгах	Нэн ховор, ховор ургамалыг таньж мэдэхгүй харьцах	Төрөл зүйл өөрчлөгдөх Устгах
<b>Ан амьтан</b>			
10	Хордолт	Хог хаягдал болон шатах тослох материалын хаягдал	Хөрсөн дэх бичил биетэн, шавж үрэгдэх
11	Дайжих	Дуу чимээ Үйлдвэрийн үйл ажиллагаа	Тухайн орчинд амьдрах боломжгүй болж дайжих
<b>Нийгэм-эдийн засгийн орчин</b>			
12	Үндсэн хөрөнгө	Татварын орлого Бүтээгдэхүүн үйлчилгээний худалдан авалт, орлого Орон сууц	Төсөвт татвар төлөх Ойролцоох оршин суугч, аж ахуй эрхлэгчдийн орлого нэмэгдэх, амьжиргаа дээшлэх Сумын дэд бүтэц сайжрах, тохилог орон сууц нэмэгдэх
13	Ажлын байр	Ажлын байр шинээр бий болох	Орон нутгийн иргэдээс ажилд авах Тогтмол орлогын эх үүсвэртэй болох

**Төслийн гол сөрөг нөлөөлөл**

Дээр өгүүлсэн болзошгүй нөлөөллийн судалгааны үр дүнгээс жонш боловсруулах үед хөрс, агаар, бэлчээр, ургамал зэрэгт ихээхэн нөлөөтэй болох нь харагдаж байна.

*Хүснэгт №4. Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа*

№	Нөлөөллийн голлох хүчин зүйл	Нөлөөлөлд өртөх орчин	Байршил	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Тоосжилтоос бохирдох	Агаар	Бутлах, нунтаглах машины орчим	50 хүн	Дунд зэрэг	Богино
2	Чимээ шуугианы физик бохирдол	Агаар	Үйлдвэрийн байранд	50 хүн	Дунд зэрэг	Богино
3	Хатуу шингэн хог хаягдал	Хөрс	Бохирын шугам, гадаад орчин	Орчны талбай	Бага зэрэг	Урт
4	Хаягдлын сангийн хаягдал	Гүний ус	Баяжуулах	Орчны талбай	Бага зэрэг	Урт
5	Мэргэжлээс шалтгаалах өвчлөл	Хүн	Ажиллагсад	50 хүн	Дунд зэрэг	Урт

#### **4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ**

Гол зорилт: Бид 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа 2019 онд “Ашид-Ананда” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн жонш баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүргээс гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан **үүрэг даалгавруудыг** биелүүлэхийг гол зорилго болгосон.

Хамрах хүрээ: Дорноговь аймгийн Даланжаргалан сумын орон нутагаас 000298191 тоот газар эзэмших гэрчилгээ бүхий 14.2 га талбай хамрагдах бөгөөд Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн хэсгүүдэд хамаарна.

#### 4.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” түүний хавсралтад төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хуваан агаар, хөрс, гадаргын ба газрын доорх ус, амьтан, ургамал, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн энэхүү төлөвлөгөөг боловсрууллаа.

БОННУ-нд тодорхойлсон байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөлөл мөн төслийн 2023 оны үйл ажиллагаатай уялдуулан гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, сэргийлэх, арилгах 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв. Төлөвлөн хэрэгжүүлэх арга хэмжээ бүрд тухайн сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, хэмжих нэгж, шаардагдах төсөв, баримтлах стандарт, хуулийн шаардлагыг тусгасан болно.

Хүснэгт №5. 2023 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>1</b>	<b>Агаар орчин</b>							
1.1	Машинаас гарах тоос шороог багасгах үүднээс замын гадаргыг шаардлагатай хэсгүүдэд засах, услах	Төслийн зам	м3	1.1	1100	1210.0	6,7,9-р сард	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003
1.2	Үйлдвэрийн орчны авто замд тэмдэгжүүлэлтийг нэмж байрлуулах	Авто зам	ш	50.0	2	100.0	6-р сард	Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
	Дүн					1310.0		
<b>2</b>	<b>Усны нөөц чанарыг хамгаалах чиглэлээр</b>							
2.1	Жонш боловсруулах үед ашиглах усны төлбөр тооцоог холбогдох байгууллагад төлөх		м3	-	-	Үйл ажиллагааны зардал	10-р сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль
2.2	Гүний худгийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоох, худгуудын тоолуурын заалтыг БОрчны хяналтын улсын байцаагчийг байлцуулан акт үйлдэж байх, ус ашиглах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулах		ш	200.0	2	400.0	5-р сард	ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/



2.3	Жонш боловсруулалтын ажлын явцад орчны тоосжилтыг бууруулахад газар доорх усны нөөцийг аль болох ашиглахаас зайлсхийж, цэвэршүүлсэн ажуйн хаягдал усыг эргүүлж ашиглах боломжийг судлах,							Жилийн туршид	/ БО-ны сайдын 1995 оны 153 дугаар тушаалын хавсралт 4 –“ Зүлэг, талбайн усалгааны түр норм /
2.4	Хаягдлын сангийн аюулгүй байдлыг хангаж ажиллах, газрын доорхи усны хяналтын цооног байгуулах	Хаягдлын сан						Жилийн туршид	
Дүн						400.0			
<b>3</b>	<b>Хөрс, ургамлын бүрхэвч</b>								
3.1	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих, автозасвар болон автозогсоолын талбайг хайрган буюу бетонон хучилттай болгох	Материалын агуулах	-	-	-	-		Жилийн туршид	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014
3.2	Тээвэрлэлтийн олон салаа зам гарахаас сэргийлж дотоод, гадаад замын 2 талаар хязгаарлах далан тэмдэг тэмдэглэгээ хийх	Авто зам	-	25.0	4	100.0		2 сард	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
3.3	Шимт хөрсний агрохимийн шинжилгээг хийлгэх, хадгалалтыг сайжруулах, салхинд хийсэхээс хамгаалж гадаргын хэсгийг ургамалжуулах	Шимт хөрс	га	-	-		Үйл ажиллагааны зардал	5-10 сард	MNS 5916 : 2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
3.4	Үйлдвэрийн талбай орчимд хог хаягдлын цэвэрлэгээ байнга хийх, эмх замбараагүй байдлыг цэгцлэх	Баяжуулах үйлдвэр	га	10				Жилийн туршид	Хог хаягдлын тухай хууль, 10.2.3,10.2.4, 10.2.7
Дүн						100.0			
<b>Нийт зардлын хэмжээ /мян.төг/</b>						<b>1810.0</b>			

**4.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Монголиан Флюор Спар ХХК-ний үйл ажиллагаанаас үүдэн 2023 онд шинээр газар хөндөгдөөгүй, нөхөн сэргээлт хийх шаардлагатай газар байхгүй тул Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний энэхүү бүлэгт нөхөн сэргээлтийн ажил оруулаагүй болно.

Бид төслийн талбайн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд 1 арга хэмжээ төлөвлөсөн.

Хүснэгт №6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж	Баяжуулах үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн хашаанд дотор тарих	ш	100	1,800.0	Тайлант жилд	MNS 6258-1:2011
<b>Нийт мян.төг</b>					<b>1,800.0</b>		

#### 4.3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монголиан Флюор Спар ХХК нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын 5.2, 5.3 дах заалтууд болон 2014 оны БОНХ-ийн сайдын А-117 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын 3.3.6-д тус тус заасны дагуу Биологийн олон янз байдлыг (БОЯБ) дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд бид 2023 онд биотехникийн арга хэмжээ болон дүйцүүлэн нөхөн сэргээлтийн арга хэмжээнүүдийг төлөвлөж байна. Дүйцүүлэн нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох орон нутгийн Засаг даргын тамгын газартай хамтран эзэнгүй орхигдсон эвдэрсэн газрыг сонгон авч техникийн нөхөн сэргээлтийг хийх болно.

Хүснэгт №7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах	Зэрлэг амьтдад өвс тэжээл өгөх биотехникийн арга хэмжээг мэргэжлийн байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх	5,000.0	Жилд нэг удаа	•БОНБУ-ний тухай хуулийн 3.1.11 •БОННУ-ний нэмэлт тодотгол тайлан /Ашид Ананда ХХК/
2	Дүйцүүлэн техникийн нөхөн сэргээлт	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгын удирдлагатай зөвшилцөн эзэнгүй орхигдсон эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны зардал	Тайлант жил	MNS 5918: 2008
<b>Нийт дүн сая.төг</b>			<b>5,000.0</b>		

#### 4.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монголиан Флюор Спар ХХК-ийн Жонш баяжуулах үйлдвэр төсөл нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт харьяалагддаг бөгөөд Даланжаргалан сумын төвөөс зүүн хойш 3 км орчимд байрладаг.

Бид өмнөх жилүүдэд нөлөөлөлд өртөгч орон нутгийн айл өрхүүдэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан тул 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй болно.

*Хүснэгт №8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		Бид өмнөх жилүүдэд нөлөөлөлд өртөгч орон нутгийн айл өрхүүдэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж дууссан тул 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй болно.	-	-	-
<b>Нийт дүн сая.төг</b>			-		

#### 4.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл одоогоор олдоогүй болно.

Хүснэгт № 9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологи, палеонтологийн дурсгалт олдвор	Үйлдвэрийн үйл ажиллагааны үед архелогийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй. Энэ тохиолдолд төрийн холбогдох байгууллагуудад мэдэгдэх бөгөөд тухайн олдворын бүрэн бүтэн байдлыг хангана	Төслийн талбайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагааны туршид	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2	Соёлын биет өв	Сум орон нутгийн хэмжээнд соёлын биет бус өвийг хамгаалах, биет бус өвийг өвлөн уламжлагчийг урамшуулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор арга хэмжээ хэрэгжүүлэх хамтран ажиллах	Сум орон нутгийн хэмжээнд	-	1,000.0	Тайлант жил	
<b>Нийт мян.төг</b>					<b>1,000.0</b>		

### 4.6. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид “Жонш баяжуулах үйлдвэр” төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа химийн бодис материалуудын худалдан авалт, тээвэрлэлт хадгалалт, ашиглалт болон устгал зэргийг Монгол улсын зохих стандарт, журамд нийцүүлэн боловсруулсан компанийн дотоод журмын дагуу гүйцэтгэнэ. Баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй химийн бодис материалын тээвэрлэлт, хадгалалт ашиглалт, түүний хаягдал сав баглаа боодлын устгалд хяналт тавьж үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төлөвлөгөөг боловсрууллаа.

Мөн энэхүү төлөвлөгөөнд байгалийн гамшиг, гал түймэр зэрэг төслийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах, хариу арга хэмжээ авах арга хэмжээг тусган боловсрууллаа.

Хүснэгт № 10. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төсөв

№	Арга хэмжээ	Эрсдлээс хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал, мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Галын аюулаас хамгаалах багаж хэрэгслийн иж бүрдлийг байрлуулах	Химийн бодисын агуулах, баяжуулах үйлдвэр, амрах байр	2	500.0	Тайлант жил	-
2		Галын дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар гаргуулах	Бүх объектод	1	Үйл ажиллагааны зардлаас	Тайлант жилд	Галын аюулгүй байдлын тухай хууль 16.1.7
3		Химийн бодис, шатах тослох материалын асгаралтыг удирдах хэрэгслийг боломжит хэмжээгээр байрлуулах, хэрэглэх зааварчилгааг байршуулах	Төслийн талбайд	3	Үйл ажиллагааны зардлаас	Тайлант жилд	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014
4		"Галын аюулгүй байдал, гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх" сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Бүх ажилтан		300.0	Жилд 2 удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль

5		Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад эрсдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах, хамгаалах багаж хэрэгслийг ашиглах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтанд хамруулах	Химийн бодистой харьцаж ажилладаг ажилчдад		Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 2.1.6, 2.1.8 заалт
6		Химийн бодистой харьцаж ажилладаг ажилтнуудад эрсдлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах, хамгаалах багаж хэрэгслийг ашиглах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтанд хамруулах.	Химийн бодисын агуулах	-	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа тогтмол	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 3.5.17 дахь заалт
7		Ажлын байрны үзлэгээр химийн бодисын агуулахын агааржуулах системийн ажиллагаа, хоолойн бүрэн бүтэн байдал, суурины идэгдэлт, тавиурын холбоосны бүрэн бүтэн байдал, химийн бодисын сав баглаа боодолд хяналт тавих	Химийн бодисын агуулах	-	Үйл ажиллагааны зардлаас	Тайлант жилд	-
8	Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ	Аюул тохиолдсон газрыг хамгаалалтанд авч, аюулын таних тэмдэглэгээг байршуулж холбогдох мэргэжлийн байгууллагыг дуудан туслалцаа авах	Химийн бодисын агуулах	-	Үйл ажиллагааны зардлаас	-	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
9		Химийн бодисын агуулахын хамгаалалтын хашаа, цоож, гэрэлтүүлгийг сайжруулах	Химийн бодисын агуулах	-	800.0	-	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458: 2014
<b>Нийт, мян.төг</b>					<b>1,600.0</b>		

### 4.7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монголиан Флюор Спар ХХК нь холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцүүлэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорин ажилладаг. Уг үйл ажиллагааны хүрээнд хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилан, ахуйн хог хаягдлыг орон нутгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт нийлүүлэх, дахивар хаягдлыг боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, аюултай хог хаягдлыг тусгайлан бэлдсэн агуулахад цуглуулж устгалд оруулах үйл ажиллагааг 2023 оны төлөвлөгөөнд оруулсан.

Хүснэгт № 11. Хог хаягдлын менежментийн төсөв

Хог хаягдлын ангилал	Төлөвлөсөн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал мян. төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Энгийн хог хаягдал	Хог хаягдлаа зориулалтын хогийн саванд цуглуулж, ангилан ялгаж хэвших, хог хадгалах түр цэгийг хаягжуулж хашаажуулах	Төслийн талбай	ш	1	900.0	Тайлант жилд	-Хог хаягдлын тухай хууль, 10.2.1, -БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаалын хавсралт журмын 2.2.2
	Үйлдвэрийн талбай орчимд хог хаягдлын цэвэрлэгээ байнга хийх, эмх замбараагүй байдлыг цэгцлэх	Баяжуулах үйлдвэр	га	1	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн туршид	Хог хаягдлын тухай хууль, 10.2.3,10.2.4, 10.2.7
	Орон нутагтай хатуу хог хаягдлын гэрээ байгуулж, тогтоосон цэгт ахуйн хог хаягдлаа хүлээлгэн өгөх, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөх	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль, 10.2.3,10.2.4, 10.2.7
	Сум, олон нийтийг хамарсан их цэвэрлэгээ, үйл ажиллагаанд оролцох	Сум, орон нутаг	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Хог хаягдлын тухай хууль, 10.2.6
	Ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг олгох, дадал зуршлыг хэвшүүлэх;	Төслийн талбай	-	-		Хагас жил тутам	Хог хаягдлын тухай хууль, 10.2.12, 10.2.16



	Дахивар хүлээн авагчийг судлах, хаягдлын ангилал тус бүрээр нийлүүлэх	Төслийн талбай	-	-		Шаардлагтай тохиолдолд	-Хог хаягдлын тухай хууль, 10.2.8, БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаалын хавсралт журмын 2.2.2
Үйлдвэрийн хог хаягдал	Засвар үйлчилгээнээс гарсан /төмөр, бусад/ хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Төслийн талбай	-	-	Үйл ажиллагааны зардлаас	Шаардлагтай тохиолдолд	Хог хаягдлын тухай хууль,
Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэх, мэдээллэх	Төслийн талбай	-	-	-	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль, 23.4
	Химийн бодисын сав баглаа боодол болон бусад аюултай хог хаягдлын хуулийн хугацаанд түр хадгалах талбайг засч тохижуулах	Төслийн талбай	-	-	1,000.0	Шаардлагатай тохиолдолд	"Хог хаягдлын тухай" хууль 23.1, 23.3, Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 5.5.5
	Аюултай хог хаягдал тээвэрлэх болон устгах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулах, аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгч акт үйлдэх	Төслийн талбай	-	-	-	Шаардлагатай тохиолдолд	Хог хаягдлын тухай хууль, 10.2.5
	Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хүлээлгэж өгөх, устгалд оруулах	Төслийн талбай	-	-	-	Жилд 2 удаа	"Хог хаягдлын тухай" хууль 10 дугаар зүйл 10.2.5 дахь хэсэг, Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
	<b>Нийт төсөв /сая.төг/</b>					<b>1,900.0</b>	

### 4.8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

ОХШХ-ийн зорилго нь тухайн төслийг хэрэгжүүлэх нутгийн байгаль орчин, нутгийн оршин суугчдад тухайн төслийн хэрэгжилтийн улмаас үзүүлэх нөлөөллийг хянах, тэдгээрийг бууруулах оновчтой арга хэмжээг сонгох, уг сонгосон арга хэмжээнүүд үр дүнгээ өгч буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн засаг захиргаа, хяналт тавих эрх бүхий байгууллагууд болон нутгийн оршин суугчдыг бодитой мэдээллээр хангахад оршино.

Төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, тэдгээрийг тодорхойлох арга, хуваарь, баримтлах стандарт, аргачлал болон холбогдон гарах зардлуудыг урьдчилан тодорхойлж, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулан хүснэгт 12-д нэгтгэн үзүүлэв.

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг хуулиудын дагуу төсөл хэрэгжүүлэгч Монголиан Флюор Спар ХХК нь орчны хяналт шинжилгээний ажлын зардлыг хариуцан гаргаж, аливаа ажиглалт, хээрийн хэмжилт, дээжлэлтийг батлагдсан аргазүй, стандартын дагуу хийж, төслийн талбайгаас авсан аливаа дээжүүдийг Монгол улсад итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж, гарсан үр дүнг тухайн жилийн тайландаа тусган ажиллана.

Хүснэгт № 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв

	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	8
	<b>Агаарын чанар</b>						
1	Тоосонцор: PM10, PM2,5	Баяжуулах үйлдвэрийн урд	Улирал тутам	4	40.0	160.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2	Зарим хийнүүд: хүхрийн давхар исэл-SO2, азотын давхар исэл-NO2, нүүрсхүчлийн хий-CO,	Баяжуулах үйлдвэрийн урд	Улирал тутам	4	50.0	200.0	
3	<b>Дүн</b>					<b>360.0</b>	
	<b>Хөрсний чанар</b>						
4	Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	Кэмпний зүүн хойд талд,	Хагас жилд нэг удаа	2	58.0	116.0	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
5	Хөрсний хүнд металлын агууламж /Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu./	Бутлуурын урд тал Хүдрийн жигдрүүлэлт хийсэн овоолго дээр Хаягдлын сангийн овоолго дээр Нүүрсний овоолгын зүүн талд	Улирал тутам	4 цэгт 4удаа	50.0	200.0	
	<b>Усны чанар</b>						
6	Усны ерөнхий химийн шинжилгээ /pH, Ca <sup>2+</sup> , Mg <sup>2+</sup> , Ca <sup>2+</sup> , NH <sub>4</sub> <sup>+</sup> ,	Гүний худаг Хаягдлын сан	Улирал тутам	4	48.0	192.0	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага,

	$Na^+, K^+, Fe^{3+}, SO_4^{2-}, HCO_3^-, Cl^-, NO_2^-, NO_3^- /$						чанар, MNS 4943:2015
7	Ундны ус, хаягдал усны бактериологийн шинжилгээ	Гүний худаг Хаягдлын сан	Улирал тутам	4	45.0	180.0	Хүрээлэн байгаа орчин, усны чанар, хаягдал ус ерөнхий шаардлага
<b>Нийт дүн</b>						<b>1048.0</b>	

### 4.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид төлөвлөгөөт жилд удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд нийт 6 төсөвт болон төсөвт бус арга хэмжээ төлөвлөөд байна. Тухайн арга хэмжээнүүдийг доорх хүсэнтгээс харна уу.

Хүснэгт № 13. Удирдлага зохион байгуулалтын төсөв

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажилчдад хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа	Удирдлага	Ажилчдын экологийн боловсролыг дээшлүүлэх, Эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадал олгох
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбарыг үйлдвэрийн бүсэд байрлуулах	300.0		ХАБЭАБО	ХАБЭА-н соёлд хэвшүүлэх зорилготой.
3	Аймгийн Засаг даргаар тээврийн замын маршрутыг тогтоолгох	Үйл ажиллагааны зардлаас	Тухайн жилд	ХАБЭАБО	
4	Борчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэн зөвлөмжийн биелэлтийг Аймгийн БОГ-т хүргүүлэх,		Тухайн жилд	ХАБЭАБО	БОХамгаалах тухай хуулийн 10-1
5	Экологийн паспорт хөтлөх		Тухайн жилд	ХАБЭАБО	
6	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд баяжуулах үйлдвэрийн хашаан дотор модны суулгац тарих		Тухайн жилд	ХАБЭАБО	
<b>Нийт</b>		<b>300,0</b>			

#### 4.10. 2023 ОНЫ БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ МЭДЭЭ

Төслийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд орон нутгийн иргэд, засаг захиргааны байгууллагуудтай нягт уялдаа холбоотой ажиллаж, нээлттэй байх, хамтран ажиллах зарчмыг “Монголиан Флюор Спар” ХХК баримталж байна.

Төслийн үйл ажиллагаа эхлэсэн цагаас хойш нутгийн малчин иргэдэд уурхайн үйл ажиллагаа, хэтийн төлөв, байгаль орчны асуудлууд ба тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замууд гэх мэт олон талын мэдээллийг уулзалт хурал, цуглаан, ганцаарчилсан уулзалтуудаар өгсөн.

2023 онд бид зөвхөн БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд танилцуулахаас гадна нээлттэй мэдээллүүдийг хүртээмжтэй байдлаар түгээх үүднээс доорх ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Хүснэгт № 14. Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах мэдээ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян. төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Багийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	10-р сар	Үйл ажиллагааны зардлаас	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	Сумын хурлын заал
2	Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт БОМТ-ний биелэлтийн тайланг холбогдох журамд заасан хугацааны дотор хүргүүлэх	Хянуулах	БОМТ болон Хяналт шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	300.0	Биелэлтийг хянуулах	Аймгийн байгаль орчны газар
<b>Нийт</b>					<b>300.0</b>		

**2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ***Хүснэгт № 15. Байгаль орчны менежментийн төсөв*

№	Зардлын төрөл	Дүн мян. төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1,810.0
2	Нөхөн сэргээлтийн төсөв	1,800.0
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	5,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төсөв	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв	1,000.0
6	Осол, эрсдэлийн менежментийн төсөв	1,600.0
7	Хог, хаягдлын менежментийн төсөв	1,900.0
8	Орчны хяналт шинжилгээ	1,048.0
9	Удирдлага зохион байгуулалт	300.0
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах	300.0
<b>Нийт зардал</b>		<b>14,758.0</b>